

СҮХБААТАР ДҮҮРГИЙН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН
 “ТӨРИЙН АЛБАН ХААГЧИЙН СУРГАЛТ” ХӨТӨЛБӨРИЙН ХҮРЭЭНД
 2023 ОНД ХИЙХ АЖЛЫН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ЖИЛИЙН ЭЦСИЙН ХЭРЭГЖИЛТ

2023 оны 12 дугаар сарын 25

д/д	Хөтөлбөрт тусгагдсан ажил	Хэрэгжүүлэх ажил	Хугацаа	Хамрагдах албан хаагчийн тоо	Хариуцах хэлтэс	Хэрэгжилтийн хувь
1	Удирдлагын академийн төрийн албан хаагчийн богино болон дунд хугацааны сургалт:	Төрийн албанд анх томилогдсон албан хаагчийг чиглүүлэх богино хугацааны сургалтад хамруулах.	2, 3 дугаар улиралд	1-2	Төрийн албанд анх томилогдсон 1 албан хаагчийг нийслэлийн Засаг даргын Тамгын газрын Хүний хөгжлийн төвөөс зохион байгуулсан 40 цагийн чиглүүлэх богино хугацааны сургалтад хамруулсан.	100
		Төрийн захиргааны албан хаагчийг дунд хугацааны мэргэшүүлэх болон давтан сургалтад хамруулах.	2, 3 дугаар улиралд	1-2	Удирдлагын академиас ирүүлсэн квотын дагуу 2023 оны 4 дүгээр болон 10 дугаар сард 1 албан хаагчийг дунд хугацааны мэргэшүүлэх сургалтад, 1 албан хаагчийг давтан сургалтад хамруулсан.	100
		Ахлах түшмэлийн болон эрхэлсэн түшмэлийн багц сургалтад шаардлага хангасан албан хаагчийг хамруулах.	2, 3 дугаар улиралд	1-2	Удирдлагын академиас ирүүлсэн квотын дагуу 2023 оны 11 дүгээр сард шаардлага хангасан 1 албан хаагчийг Ахлах түшмэлийн багц сургалтад хамруулсан.	100
2	Богино хугацааны сургалт: /30 хүртэл хоног/	Албан хаагчдыг төрийн байгууллагын болон сургалтын байгууллагын сэдэвчилсэн сургалтуудад хамруулах.	Жилдээ	5-10	Нийслэлийн Засаг даргын Тамгын газар болон төрийн бусад байгууллагуудаас зохион байгуулсан мэдлэг ур чадвар олгох 24 удаагийн сургалтад нийт давхардсан тоогоор 246, мэргэшүүлэх чиглэлийн сургалтад 4, байгууллагын 5 удаагийн	100

					сургалтад давхардсан тоогоор 281 албан хаагч хамрагдсан.	
		Дотоод, гадаадын ижил төстэй үйл ажиллагаа явуулдаг байгууллагын үйл ажиллагаатай танилцах, туршлага судлах сургалтуудад хамруулах.	Жилдээ	5-10	Сүхбаатар дүүрэгтээ хамтын ажиллагаатай БНСУ, Япон улс, БНХАУ руу туршлага судлах сургалтад 83 албан хаагч хамрагдсан байна.	100
		“Мэдээллийн цаг”-ийн сургалт зохион байгуулах.	Жилдээ	Бүх албан хагчид	“Мэдээллийн цаг”-ийг 6 удаа зохион байгуулж Засаг даргын Тамгын газрын албан хаагчдыг бүрэн хамруулсан.	70
3	Дунд хугацааны сургалт: /1 сараас дээш 1 жил хүртэл/	Мэргэшүүлэх онол арга зүйн сургалтуудад хамруулах.	Жилдээ	1-2	Монгол бичгийн үндэсний хөтөлбөрийг үе шаттай хэрэгжүүлэх ажлын хүрээнд Төрийн албан хаагчдад зориулсан Монгол бичгийн сургалтыг 2023 оны 09 дүгээр сараас эхлэн 2 сарын хугацаанд 2 ээлжээр зохион байгуулж, анхан шатны сургалтад 72, дунд шатны сургалтад 68 албан хаагч хамрагдсан.	100
4	Урт хугацааны сургалт: /1 жилээс дээш/	Хос мэргэжил эзэмших, боловсролын түвшин ахиулах, магистр, докторын болон бусад сургалтад хамрагдахад дэмжлэг үзүүлэх.	Жилдээ	1-2	2022-2023 оны хийчээлийн жилд боловсролын түвшин ахиулах магистрын хөтөлбөрт 6, докторын хөтөлбөрт 1 албан хаагч тус тус хамрагдсан. Үүнээс 2023 онд магистрын хөтөлбөрийг 3 албан хаагч төгсөж, дипломоо авсан. Бусад албан хаагчид үргэлжлүүлэн суралцаж байна.	100
5	Сургалт, эрдэм шинжилгээний байгууллагад багшлах, эрдэм шинжилгээний ажил эрхлэх	Албан хаагчдыг хуулиар зөвшөөрсөн давхар ажил эрхлэх боломжоор хангах.	Жилдээ	1-2	Сонгуулийн Ерөнхий хорооноос зохион байгуулсан “Хариуцлагатай сонгогч” сургалтын сургагч багшаар 2, Удирдлагын академийн “Алсын хараа 2050” МУ-ын урт хугацааны бодлогын баримт бичгийг төрийн албан хаагчдад танилцуулах	100

					сургалтын сургагч багшаар 10 албан хаагч суралцаж гэрчилгээ авсан. Сургагч багшаар бэлтгэгдсэн албан хаагчдыг төрийн байгууллагуудад сургалт хийх боломжоор хангасан.	
Дундаж хувь				96,7		

ХЯНАСАН:
ТӨРИЙН ЗАХИРГААНЫ УДИРДЛАГЫН
ХЭЛТСИЙН ДАРГА

В.ГОМБОДОРЖ

НЭГТГЭСЭН:
ХҮНИЙ НӨӨЦ, ЁС ЗҮЙ, ХӨРӨНГӨ ОРЛОГЫН
МЭДҮҮЛЭГ ХАРИУЦСАН АХЛАХ МЭРГЭЖИЛТЭН

М.ОЧМАА